

ОНГОН СУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

2022.09.29

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлыг зохион байгуулж, сумын засаг даргад нэр дэвшүүлэх албан тушаалтныг тодруулж, санал хүргүүлэх, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын явцыг хэлэлцсэн.

Байгууллага, мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг шалгах ХШҮ-ний баг төлөвлөгөөт шалгалтыг зохион байгуулсан.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Төсөвт байгууллагуудын 2021 оны санхүүгийн баримтанд аудитын шалгалт хийгдсэн.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа бага сургуулийн барилгын ажилд мэргэжлийн яам, агентлагт хүсэлт тавьж хяналт шалгалтыг хийлгэж, зогссон байсан байрилгын үйл ажиллагааг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж үргэлжлүүлэн хийж эхлүүлсэн.

Энтерпренершипд суурилсан “Хувь хүний ур чадвар”-ыг хөгжүүлэх 2021-2022 оны төслийн хүрээнд шалгарсан “DreamLand” төслийн танхимын нээлтийг хийсэн.



Сумын хэлний бодлогын зөвлөл, ЕБС хамтарч “Бийрийн бичлэг”-ийн багш урьж 5 хоногийн сургалтыг зохион байгуулж, 4 багш, 4 байгууллагын 5 албан хаагч, 28 сурагч хамруулан, орон нутагт Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчилах ажлыг зохион байгуулав.



“Байгалийн ухааны судлагдахуун”-аас 6-12 дугаар ангийн эцэг эхчүүд, багш нарын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Гар бөмбөг”ийн тэмцээн зохион байгуулж 54 эцэг эхийг хамруулав.



“Хувь хүний ур чадвар”-ыг хөгжүүлэх Энтерпренершипд суурилсан БАГШ ЗӨВЛӨХ бэлтгэх сургалт 09 дүгээр сарын 22-26-ны хооронд явагдав.

Цэцэрлэгийн салбар бүлгийн дээврийг ОНХС-ийн хөрөнгө 19.000.000 төгрөгөөр гүйцэтгүүлж, хүлээн авахад бэлэн болсон.

“Намрын ногоон өдрүүд-Нэг баг нэг бренд” үзэсгэлэн худалдаа, Төрийн байгууллагын “Нээлттэй хаалга”-ны арга хэмжээнд Эрүүл мэндийн төвөөс иргэдэд “Элгээ хайрлацгаая”, В, С вирус зөвлөмжийг хүргэн, урьдчилан сэргийлэх үзлэг үзлэгийн талаар 32, эрт илрүүлэг оношлогооны талаар 52 иргэнд эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.



“Нүдэн” багийн өдөрлөгийн арга хэмжээнд оролцогчдод В, С вирусын шинжилгээг 45 иргэнээс авч, шинээр В вирус 2, С вирус 1-ийг илрүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдыг эрт илрүүлгийн үзлэгт хамруулав.



Соёлын ажилтны өдрөөр “Соёлын орон зай” нэртэй хөтөлбөрт үйл ажиллагааг зохион байгуулж, Соёлын өв, орон нутаг судлах танхимыг сурталчилах, албан байгуулаллагуудын дунд Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан. 14 хүнд үйлчилсэн.



Соёлын төвийн дуу хөгжмийн багш үндэсний хөгжим, цахилгаан хөгжим, даралтат хөгжмийн дугуйланг хүүхэд болон насанд хүрэгчдийн ангиллаар хичээллүүлж эхлэн, 18 хүүхэд хамрагдаж долоо хоног бүрийн Пүрэв, Баасан гарагт хичээллэж байна.



МУИС-ийн археологийн танхимын багш, оюутнуудын баг тус сумын “Таван толгойд” малтлаг хийж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьж, нөхөн сэргээлтийг хийлгэсэн. Судалгааны багийн ахлагчаас товч тайланг баримт болгон авч үлдсэн.



Соёлын төв, Нүдэн багийн засаг даргын санаачлагаар ардын авьяастан Х.Энхбаярын эмчилгээний зардалд зориулж “Сүүн сэтгэл” хандивын тоглолтыг сумын үе үеийн ардын авьяастнуудад уриалан, хамтран зохион байгууллаа. Тоглолтод 19 ардын авьяастан, ЕБС-ийн 1 сурагч оролцож нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан. /Тоглолтыг 272 насанд хүрэгч, 100 хүүхэд үзсэн/



Дөрөв: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Аймгийн засаг даргын 06 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэхээр 2022-2023 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг сумын засаг даргын захирамжаар томилж, байгууллага, ААН, иргэдийн бэлтгэл ажилтай танилцаж, дүнг аймгийн ИТХ-ын даргатай ажилласан ажлын хэсэгт танилцуулсан.

“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин сурталчилж, харилцан туршлага солилцуулах, орон нутагт үйлдвэрлэсэн

хүнсний бүтээгдэхүүн, гар урлалын бүтээлийг иргэдэд хүргэх “Намрын ногоон өдрүүд-Нэг баг нэг бренд” үзэсгэлэн худалдаа, төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг зохион байгуулж, 5 байгууллага, 7 ААН, 22 иргэн оролцсон.

Үзэсгэлэн худалдаан оролцогчдоос 6 төрөлд шалгаруулж, Сүхбаатар аймагт зохион байгуулагдах “Сүхбаатарт үйлдвэрлэв-Намрын ногоон өдрүүд-2022” үзэсгэлэн худалдаанд оролцогчдыг тодруулсан.



Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх хадлангийн салаа 4 хүний бүрэлдэхүүнтэй үүрэг гүйцэтгэн өнөөдрийн байдлаар 5500 боодол өвс бэлтгээд байна.



Сумын төвд улирлын нохой устгалын ажлыг зохион байгуулж, 120 нохой устгаж иргэдийн аюулгүй байдлыг хамгаалж, хүн, амьтны халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлсэн.

Албан байгууллага, ААН, иргэдийг хамруулан байгууллага, ААН-ийн эзэмшил, сумын төвийн ойр орчимд их цэвэрлээгний ажлыг зохион байгуулсан.

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ